



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

210620А Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,

Засгийн газрын III байр, Утас: 32-14-33, Факс: 32-45-18

E-mail: nso@magicnet.mn, http://www.nso.mn

2014.03.27 № 03/264


танай _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА**

Үндэсний статистикийн хорооны дарга
С.Мэндсайханы Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк
хотод 2014 оны 02 дугаар сарын 27-ноос 03 дугаар
сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан НҮБ-ын
Статистикийн комиссын чуулганд оролцсон тухай илтгэх
хуудсыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР



Т.ГАНТӨМӨР

2014.04.17
1400517

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ИЛТГЭХ ХУУДАС

2013 оны 03 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Үндэсний Статистикийн Хорооны дарга С.Мэндсайханы НҮБ-ын Статистикийн Комиссын ээлжит 45-р чуулганд оролцсон тухай

I. Чуулганд оролцсон тухай

Үндэсний Статистикийн Хорооны дарга С.Мэндсайхан НҮБ-ын Статистикийн Комиссын (НҮБСК) ээлжит 45-р чуулганд 2014 оны 02 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 7-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо оролцов. ҮСХ-ны даргыг тус Хорооны Макро эдийн засгийн статистиктийн газрын (МЭЗСГ) дарга Б.Бадамцэцэг, Хүн ам, нийгмийн статистикийн газрын (ХАНСГ) дарга Д.Оюунчимэг болон төслийн ажилтан С. Алтанцэцэг нар дагалдан ажиллав.

Чуулганд оролцсон зорилго нь:

- Монгол улс НҮБСК-ийн гишүүн орны хувьд тус Комиссын 45-р чуулган, түүний салбар хуралдаан болон бусад арга хэмжээнд оролцон өөрийн орны санал, байр суурийг илэрхийлж, холбогдох шийдвэрт тусгуулах;
- Монгол Австралийн хамтран санаачилсан “Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн” Улаанбаатар хотын группын өргөтгөсөн уулзалтыг зохион байгуулах;
- НҮБСХ, олон болон хоёр талт хамтын ажиллагаатай байгууллагуудын удирдлагатай хамтын ажиллагааны талаар санал солилцож, хамтын ажиллагааг идэвхижүүлэх зэрэг байв.

II. НҮБСК-ын 45-р чуулганы явц ба хэлэлцэх, мэдээлэх асуудлууд

2.1 НҮБСК-ын 45-р чуулганы явц

НҮБСК-ын ээлжит 45 дугаар чуулган ба түүний салбар хуралдаанууд 2014 оны 2 дугаар сарын 28-аас 3 дугаар сарын 7-ны өдрүүдэд НҮБ-ын төв байранд Нью Йорк хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Чуулганд НҮБСК-ийн гишүүн орон, НҮБ-ын гишүүн болон гишүүн бус 130 гаруй улсын төлөөлөгчдөөс гадна 40 гаруй байгууллага, үүний дотор НҮБ-ын системийн байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцсон байна.

НҮБСК-ын 45-р чуулганы даргаар Жилл Матесон (Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс), орлогчоор Габриела Юкович /БНУУ/, Пабло Тактук (Доминиканы Бүгд Найрамдах Улс) болон Ма Жиантан (БНХАУ) нар, тусгай илтгэгчээр Жозеф Тедоу (Камерун) тус тус сонгогдож ажиллалаа. 2014 оны 3-р сарын 4-ний өдрийн хуралдаанаар чуулганы хөтөлбөр, ажлын зохион байгуулалтыг баталж олон улсын 6 байгууллагыг ажиглагчаар оролцуулахаар урилаа.

НҮБСК-ны даргын үүрэг гүйцэтгэгч ноён Штефан Швайнфест чуулганыг нээж хэлсэн үгэндээ 44 дүгээр чуулганаас хойших нэг жилийн хугацаанд статистикийн салбарыг хамарсан 34 илтгэл боловсруулан гаргасныг сайшаан тэмдэглэж, ИБУИНВУ, ДБ, НҮБХАС, Парис 21, ECOWAS Нарийн бичгийн дарга нарын газар, Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдээлэл нотолгооны санаачлага /EDGE/ төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байгууллагууд болон бусад бүс нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн байгууллагуудад талархлаа илэрхийлэв.

Ноён Штефан Швайнфест дэлхийн статистикийн нийгэмлэгийн өмнө 2014 оны МХЗ-ын тайланг эцэслэн гаргах, 2015 онд МХЗ-ын хамгийн сүүлийн тайланг бэлдэх, 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаанд оролцох зэрэг томоохон ажлууд байгааг дурдаад Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах бүх шатанд статистик гол цөм нь байх бүрэн үндэслэлтэй гэлээ. Тэрээр цааш хэлэхдээ НҮБ, НҮБСК нь мэдээллийн хувьсгалд голлох үүрэгтэй бөгөөд статистикийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангаж, нээлттэй мэдээлэлийн асуудлаар хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх ажиллах хэрэгтэй юм гэж онцлон тэмдэглэв. Ноён Штефан Швайнфест үйл ажиллагааг үндсэн чиглэл болгон ажиллана гэлээ. Үүнд:

- ҮТС 2008-ыг хэрэгжүүлэх ажлыг өргөжүүлж, холбогдох статистикийг сайжруулах;
- Байгаль орчин-эдийн засгийн нэгдсэн тооцооны систем 2012-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх;

- Дарга нарын анд нөхдийн бүлгийн хэрэгжүүлж буй олон улсын худалдааны статистик ба эдийн засгийн глобальчлалыг хэмжих, бизнесийн статистик ба олон улсын худалдааны статистикийн уялдаа холбоог сайжруулах ажлыг үргэлжлүүлэн дэмжих;
- “Том” тоон мэдээллийн талаархи олон улсын ажлын хэсгийг байгуулах;
- Орон зайн мэдээдэл ба статистикийн үйл ажиллагааг ойртуулах;
- 2020 оны ээлжит Хүн ам, орон сууцны тооллогын (ХАОСТ) бэлтгэлийг хангаж, ХАОСТ-ын зарчим ба зөвлөмжийг эцэслэх;
- Жендерийн статистикийн хөтөлбөрийн нэг хэсэг болох Дэлхийн эмэгтэйчүүд 2015 тайланг бэлтгэх;
- Байгаль орчны статистикийг хөгжүүлэх хүрээ (Framework for the Development of Environment Statistics), аж үйлдвэр, эрчим хүчний статистикийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулах;
- Дарга нарын анд нөхдийн бүлэгтэй албан ёсны статистикийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- Мэдээлэл тархах вебсайт, ялангуяа COMTRADE-ийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгож, НҮБСХ-ийн вебсайтыг орчин үеийн харилцааны арга хэрэгсэл болгох;
- 2015 онд Дэлхийн статистикийн өдрийг тэмдэглэх бэлтгэлийг хангах;
- Техник туслалцааны хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх зэрэг болно.

ҮСХ-ны төлөөлөгчид НҮБСК-ийн 45-р чуулганы 6 удаагийн хуралдаан, Албан ёсны статистикийн үндсэн зарчмын 20 жилийн арга хэмжээ болон дараах 19 салбар хуралдаан, семинарт оролцов. Үүнд:

- Мэдээллийн хувьсгалыг удирдах нь;
- Үндэсний статистикийн системийн санхүүжилтийг сайжруулах;
- 2010 оны хүн амын тооллого ба улс орнуудын туршлага;
- Олон улсын хөгжлийн агентлагууд үндэсний статистикийн байгууллагуудтай хэрхэн илүү сайн хамтран ажиллах вэ хэлэлцүүлэг;
- Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй ба хөдөөгийн статистик;
- Жендерийн мэдээллийн хувьсгалын шинэ стратеги;
- Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдээлэл нотолгооны санаачлага /EDGE/ төсөл;
- Байгаль орчин-эдийн засгийн нэгдсэн дансны систем;
- Иргэний бүртгэл ба хүн амын ердийн хөдөлгөөний статистик (CRVS);

- Нийгмийн бодлого боловсруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай хөгшрөлтийн статистикийн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг сайжруулах нь;
- ҮСХ-дод зориулсан нээлттэй мэдээллийн хэлэлцүүлэг;
- Олон улсын өрхийн судалгааны сүлжээний удирдлагын бүлгийн хурал;
- АНДЭЗНК-ийн Статистикийн Хорооны Товчооны 8-р хурал;
- Хөдөө аж ахуй ба хөдөөгийн статистикийг сайжруулах олон улсын стратегийн Удирдах Хороо;
- Хөдөлмөрийн статистикийн олон улсын 19-р хурлын үр дүн: Статистикийн шинэ хүрээ
- Гэмт хэргийн статистик;
- Аялал жуулчлал ба олон улсын худалдааны статистикийн чадавхийг бэхжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлийн статистик;
- ERETES програм хэрэглэгчийн уулзалт зэрэг болно.

АНДЭЗНК-ийн Статистикийн Хорооны Товчооны 8-р хурлаар 2014 оны 12-р сарын 17-19-ны өдрүүдэд Тайландын Бангкок хотноо болох тус Хорооны 4-р чуулганы хөтөлбөрийн төсөл, НҮБСК-ийн 45-р чуулганаар хэлэлцэх “АНДЭЗНК-ийн тайлан ба 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөр: АНД-н бүс нутгийн үзэл баримтлал” илтгэлийн талаар хэлэлцлээ. Уг чуулганаар хэлэлцэх асуудлуудын нэг болох Албан ёсны статистикийн үндсэн зарчмын хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагын хүрээнд МУ-ын ҮСХ-ноос олон улсын цогц үнэлгээний үр дүнгийн талаар илтгэл тавих, улмаар Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн Улаанбаатар хотын бүлгийн (УБХБ) үйл ажиллагааг мэдээлэх асуудлын хүрээнд танилцуулахаар болов.

Дэлхийн банкнаас (ДБ) зохион байгуулсан ҮСХ-дод зориулсан нээлттэй мэдээллийн хэлэлцүүлгээр ҮСХ ба нээлттэй мэдээллийн уялдаа холбооны талаархи ажлын хэсгийн тайлан, нээлттэй мэдээллийн боломж ба эрсдэл, мэдээллийг нээлттэй болгож буй болон нээлттэй мэдээллийг ашиглаж буй улс орнуудын статистикийн байгууллагын туршлагыг хэлэлцэж, санал бодлоо солилцлоо. ҮСХ нь ДБ-ны хэрэгжүүлсэн Нээлттэй мэдээллийн судалгаанд оролцсон орны хувьд статистикийн мэдээллийг нээлттэй болгож буй МУ-ын ҮСХ-ны туршлагын талаар мэдээлэл хийв.

НҮБСХ-ээс Хөгжлийн тооцоо/Ногоон эдийн засаг төслийг төсөл хэрэгжүүлэх орнуудад танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уг төслийн гол үр дүн нь арга зүйг боловсруулах, үзүүлэлтүүдийг тодорхойлох, мэдээллийг боловсруулахад сонгогдсон улс орнуудад техникийн услалцаа үзүүлэх юм. Төсөлд Өмнөд Америк, Азиас тус бүр 4 орон хамрагдаж буй бөгөөд 2014-2015 онд хэрэгжих юм. Төслийн хэрэгжүүлэхэд Монгол улс сонгогдсон ба ҮСХ хэрэгжүүлэх юм.

2.2 Чуулганаар хэлэлцсэн, танилцуулсан асуудлууд

НҮБСК-ын 45-р чуулганаар нийт 14 асуудал хэлэлцэж, 18 асуудал танилцууллаа.

А) Хэлэлцэж, шийдвэр гаргасан асуудлууд

Албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын хэрэгжилт

НҮБСК-аас Дарга нарын анд нөхөд бүлгийн боловсруулсан тайланг сайшааж, албан ёсны статистикийн үндсэн зарчмууд хэмээх энэхүү чухал баримт бичиг дээр үргэлжлүүлэн ажиллахыг хүслээ. Албан ёсны статистикийн үндсэн зарчмыг Ерөнхий ассемблейгээс баталсаны ач холбогдлыг улс төрчид, мэдээлэл нийлүүлэгчид, хувийн салбарынханд таниулан мэдүүлж, үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх удирдамжийг улс орнуудын сайн туршлагаар баяжуулж, улс орон бүхэн Статистикийн тухай хууль болон холбогдох баримт бичигтээ тусгах нь зүйтэй гэж зөвлөв. Түүнчлэн 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөр нь Үндсэн зарчмын хэрэгжилтийг шинэ шатанд гаргах боломжийг бий болгож байна гэж үзэв.

Статистикийн Комиссын ажлын арга, барил

Чуулганаас тайланд тусгасан зөвлөмжүүдийг сайшаан дэмжихийн зэрэгцээ чуулган хооронд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, улс орнууд, олон улсын байгууллагуудыг мэдээллээр хангах, экспертийн түвшинд хамтын ажиллагааг идэвхижүүлэх хэрэгтэйг тэмдэглэв.

Хөтөлбөрийн дүгнэлт: Хөгжлийг бүрэн төгс хэмжих нь

НҮБСК-аас Дарга нарын анд нөхөд бүлгийг богино хугацаанд эрчимтэй ажиллаж, “Тогтвортой хөгжлийн зорилтууд” Нээлттэй ажлын хэсэгтэй нягт хамтран ажилласанд талархлаа. Чуулганы төлөөлөгчид тогтвортой хөгжил ба сайн сайхан амьдралын үзүүлэлтийг тооцох, 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг боловсруулахад статистикийн байгууллагууд идэвхитэй оролцох, мэдээллийн хувьсгал, мэдээллийн хэрэгцээ ба дутагдалтай байдал зэрэг олон асуудлаар санал дэвшүүлэв. НҮБСК-ын чуулганаас Дарга

нарын анд нөхөд бүлгийн 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээг тогтоох үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг баталж, мэдээллийн эх үүсвэр, арга, аргачлалыг боловсруулахад анхаарч ажиллахыг хүслээ. Түүнчлэн 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөрийн мэдээллийг боловсруулан гаргахад өрхийн судалгаа чухал үүрэгтэй хэмээн үзэж, уг асуудлыг Дарга нарын анд нөхөд бүлэг тунгаан үзэж, үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгахыг санал болгов.

Үндэсний тооцооны систем (ҮТС)

Чуулганаас НҮБ-ын Агентлаг дундын нарийн бичгийн дарга нарын газрын ҮТС 2008 ажлын хэсгийн (ISWGNA) тайланг сайшааж, ажлын хөтөлбөрийг баталж, ҮТС-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой урган гарч буй тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлуудад анхаарлаа хандуулж, хэрэгжилтийг тайлагнахыг хүслээ. ҮТС 2008-ыг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, бүс нутгийн статистикийн комиссийн техникийн туслалцаа, улс орнуудын хүчин чармайлт нэн чухал юм. ҮТС 2008-ыг хэрэгжүүлэх зөвлөмж, гарын авлага, зааврыг НҮБ-ын албан ёсны бүх хэл дээр орчуулан гаргах, хөгжиж буй орнуудад статистикийн нэгдсэн хөтөлбөр боловсруулах, ҮТС-ийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй байгааг цохон тэмдэглэж, статистикийн боловсруулалт, институци, хэрэглэгчтэй харилцах харилцаа, ҮТС, эдийн засгийн статистикийг боловсронгуй болгоход улс орон бүрийн санаачлага ихээхэн ач холбогдолтой хэмээн үзлээ. Цаашилбал статистикийн нэгдсэн хөтөлбөрийн загварыг бий болгох, үндэсний түвшинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн олон улсын түвшинд харьцуулагдах боломжийг хангах зорилго бүхий Дарга нарын анд нөхдийн бүлгийг байгуулахаар шийдвэрлэв.

Байгаль орчин-эдийн засгийн нэгдсэн данс (БОЭЗНД)

БОЭЗНДС Үндсэн хүрээ, 2012 (SEEA Central framework, 2012) зөвлөмжийг улс орнуудад нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж буй Хорооны ажлыг сайшааж, уг Үндсэн хүрээ нь 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн зорилтыг хэмжих статистик үзүүлэлтийн хүрээ болох тул үүнийг хэрэгжүүлэх ажлыг статистикийн системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөртөө тусган ажиллахыг улс орнуудад уриалав. Чуулганаас БОЭЗНД-ны Үндсэн хүрээг хэрэгжүүлэх гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, техникийн баримт бичиг боловсруулах ажлаа үргэлжлүүлж, данс байгуулахад шаардлагатай статистикийн үндсэн мэдээллийг бий болгоход анхаарч ажиллахыг хүслээ. Түүнчлэн байгаль орчны үйл ажиллагаа, бараа үйлчилгээний салбарын ангилал зэрэг чиглэлээр судалгаа явуулах техникийн хороо байгуулахаар шийдвэрлэв.

Чуулганаас БОЭЗНДС-ийн Үндсэн хүрээг хэрэгжүүлэх, хүснэгт, дансыг байгуулахтай холбоотойгоор УБХБ зэрэг олон улсын санаачлагаар хийгдэж буй ажлуудтай танилцаж, хамтран ажиллах, Сангийн яам, Байгаль орчны яам, орон зайн мэдээллийн байгууллага зэрэг байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах, экосистемийн үзүүлэлтийг тооцох, үнэлэх санаачлага, байгууллагатай хамтын ажиллагаа тогтоохыг зөвлөж, БОЭЗНД-ны Экосистемийн тооцоог турших техникийн хороог байгуулахаар шийдвэрлэв.

Олон улсын худалдаа, эдийн засгийн глобальчлалын статистик

Чуулганаар хил дамнансан эдийн засгийн харилцаа, түүний нийгэм эдийн засгийн нөлөөг илэрхийлэх зарим үзүүлэлтийг тооцоход гарч буй хүндрэлтэй асуудлыг хэлэлцэж, Дарга нарын анд нөхөд бүлгээс *mirror* статистик, мэдээлэл гаргаж буй байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохицуулалт, микро мэдээллийг солилцох хууль эрх зүйн орчин, үндэстэн дамнансан олон улсын корпорациудаас мэдээлэл авах боломж, хил дамнансан албан бус худалдаа, жижиг дунд үйлдвэрлэлийн үүрэг, дэлхийн НАХ-ийн мэдээллийн эх үүсвэр, бүс нутгийн худалдааны онцлог зэрэг олон асуудалд анхаарах хэрэгтэй байгааг онцоллоо. Дарга нарын анд нөхөд бүлгээс нэмэлт мэдээлэл цуглуулах, ялангуяа судалгаа явуулахтай холбоотой зөвлөмжүүдийн үр ашиг ба зардлын тооцоог хийж байх, санал болгож буй концепцийн хүрээ нь ҮТС-ийн одоогийн хүрээтэй уялдаж, нийцэж буй эсэх зэрэгт дүн шинжилгээ хийхийг хүсч, бүлгийн зүгээс олон улсын худалдаа ба эдийн засгийн глобальчлалыг тооцох үзэл баримтлалыг НҮБСК-ийн 46-р чуулганы үеэр илтгэхийг зөвшөөрөв.

Мэдээлэл харилцааны технологийн хөгжилд гүйцэтгэх үүрэг

НҮБСК-ээс Түншлэлийн бүлгийн МХТ-ийн хөгжилд үзүүлэх нөлөөг тооцох, хэмжих талаар хийсэн ажлыг сайшааж, цаашид хийх олон ажил буйг тэмдэглэв. МХТ-ийн статистик нь дэлхийн мэдээллийн нийгэмлэг, 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөр, мэдээллийн хувьсгалын асуудалд чухал ач холбогдолтой болохыг онцолж, МХТ-ийн статистикийн хүртээмж, мэдээллийн чанарын асуудлаархи зөвлөмжийг хүлээн авч буйгаа илэрхийлэн, МХТ-ийн үзүүлэлтийн шинэчилсэн жагсаалтыг батлан, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дэмжлээ.

Олон улсын өртгийн зэрэгцүүлсэн хөтөлбөр

ДБ-ны Олон улсын өртгийн зэрэгцүүлсэн өртгийн хөтөлбөрийн тайланг авч хэлэлцээд, энэхүү хөтөлбөр нь дэлхийн 199 орны статистикийг багтаасан эрдэмтэн, судлаач, бодлого боловсруулагчдад асар их ач холбогдолтой, үнэ цэнэтэй хөтөлбөр болжээ хэмээн сайшаав.

Олон улсын өртгийн зэрэгцүүлсэн хөтөлбөр 2011-ийн үр дүнг хэвлэн нийтлэх нөхцөл бүрэн хангагдсан ба 2014 оны 4-р сарын 30 гэхэд үр дүнгийн хураангуй ба үндсэн баримт бичгийг, 2014 оны зун гэхэд дэлгэрэнгүй, нэгдсэн тайланг гаргах шийдвэрийг дэмжлээ. Түүнчлэн “Measuring the real size of the world economy”, “Operational guidelines and procedures for measuring the real size of the world economy” хэмээх номуудыг хэвлэн гаргаж буй нь Олон улсын өртгийн зэрэгцүүлсэн хөтөлбөрийн арга зүйн зарчмыг нэвтрүүлэхэд хүрсэн ололт амжилт мөн болохыг тэмдэглэж, бүс нутгийн үр дүнгээ хэвлэн нийтэлсэн Евростат, Баруун Ази болон ТУХН-т баяр хүргэв. Чуулганаас 2011 оны Олон улсын өртгийн зэрэгцүүлсэн хөтөлбөрийн тайланг НҮБСК-ийн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх зорилго бүхий Дарга нарын анд нөхөд бүлгийг байгуулахыг зөвшөөрөв.

Хөгжлийн бэрхшээлийн статистик

Чуулганаас хөгжлийн бэрхшээлийн статистикийн чанар, олдоц, хүртээмж, олон улсад харьцуулах боломж зэрэг асуудлаар Вашингтон группийн хийсэн ажил, тооллого болон түүвэр судалгаанд нэмж оруулах асуултуудыг боловсруулж, туршсаныг сайшаан тэмдэглэж, цаашид хөгжлийн бэрхшээлийн үзүүлэлтийг тооцоход улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, үзүүлэлтийг тооцоход захиргааны мэдээг ашиглах боломжийг судлах, боловсруулсан асуултуудыг тооллого, судалгаанд тусган оруулах заавар, зөвлөмжөөр хангах, чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийхийг хүслээ. Түүнчлэн Вашингтон группийг НҮБХС, ДЭМБ-тай хамтран ажиллаж буйд талархлаа илэрхийлж, тус бүлгийн 2014-2015 оны ажлын хөтөлбөрийг дэмжив.

Том мэдээлэл (big data) ба статистикийн системийн шинэчлэл

НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн даргын “Том мэдээлэл ба статистикийн системийн шинэчлэл” тайланг сайшаан хүлээн авч, Том мэдээллээс үүдэн гарах боломж ба эрсдэл, том мэдээлэл нь статистикийн эх үүсвэр байж болох талаар судалгаа хийж, статистикийн системийг шинэчлэх нь зүйтэй хэмээн үзлээ. Том мэдээллийг хэрхэн хэрэглэх, түүний албан ёсны статистикт үзүүлэх нөлөөг судлах зорилго бүхий олон улсын ажлын хэсгийг байгуулах төслийг дэмжиж, шинээр байгуулагдах ажлын хэсгийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгавал зохих зарим асуудлыг санал болгов. Түүнчлэн ажлын хэсгийн анхны хуралдааныг БНХАУ зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

НҮБСХ-ээс эрхлэн гаргадаг хэвлэмэл бүтээгдэхүүнүүд

Чуулганаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “НҮБСК-ийн хэвлэмэл бүтээгдэхүүн” тайланг сайшаан хүлээн авахын зэрэгцээ тус хэлтсийн хэвлэмэл бүтээгдэхүүн, түүнийг тархаах стратегид үнэлгээ хийх, цахим хэлбэрт шилжих саналыг дэмжиж буйгаа илэрхийлэв. Түүнчлэн арга зүйн чиглэлээр гарч буй хэвлэмэл бүтээгдэхүүнийг НҮБ-ын албан ёсны бүх хэлүүдэд орчуулах нь статистикийн хэм хэмжээ, стандартыг улс орнуудад хэрэгжүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэв.

НҮБ-ын системийн хүрээнд статистикийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

Мексик улсын удирдлагын дор ажиллаж буй Дарга нарын анд нөхөд бүлгийн тайлан, хэрэгжүүлсэн ажлыг сайшааж, НҮБ-ын статистикийн дарга нарын уулзалтыг тогтмол зохион байгуулах саналыг батлав.

Дэлхийн статистикийн өдөр

Чуулганаас Дэлхийн статистикийн өдрийг 2015 оны 10-р сарын 20-ны өдөр “Статистик илүү оновчтой шийдвэр гаргах, илүү сайн хөгжил, сайн сайхан амьдралын төлөө” уриан дор зохион байгуулах саналыг дэмжлээ. Энэхүү урианы үгийг эцэслэн боловсруулах, Дэлхийн статистикийн өдрийг тэмдэглэх Ерөнхий Ассемблейн тогтоолын төслийг танилцуулах, уг арга хэмжээг сурталчлах, улс орнуудад тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг гаргав.

Бүс нутгийн статистикийн салбарын хөгжил

Чуулганаас АНДЭЗНК-ийн тайлан, ялангуяа 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөрт статистикийн гүйцэтгэх үүргийн талаархи санааг өндрөөр үнэлж, чуулганы үеэр бүс нутгийн орнуудын статистикийн хөгжлийг харуулсан видео сурталчилгаа үзүүлсэнд талархлаа (МУ-ын статистикийн ололт амжилт, шинэ санаачлагыг харуулсан видео сурталчилгаа чуулганы үеэр байнга явж байв). Түүнчлэн, АНДОСИ-ээс зохион байгуулж буй сургалт, АНДЭЗНК-ийн чадавхийг бэхжүүлэх бүс нутгийн хөтөлбөр, арга хэмжээг сайшааж, цаашид үндэсний статистикийн тогтолцоог бэхжүүлэхэд хөрөнгө оруулах, статистикийн бүтээгдэхүүний чанар, бүс нутгийн байгууллагуудтай сайн туршлагаа хуваалцах нь нэн чухал болохыг тэмдэглэв.

В) Мэдээлсэн асуудлууд

НҮБСК нь дараах асуудлаар мэдээлэл хийсэн юм. Үүнд:

- Хүн ам зүйн статистик;

- Хүн амын суурьшлын статистик;
- Жендерийн статистик;
- Мансууруулах бодис ба түүний хэрэглээний статистик;
- Гадаад шилжих хөдөлгөөний статистик;
- Соёлын статистик;
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн статистик;
- Эрчим хүчний статистик;
- Үйлчилгээний гадаад худалдааны статистик;
- Аялал жуулчлалын статистик;
- Үнийн статистик;
- Богино хугацааны эдийн засгийн үзүүлэлтүүд;
- Байгаль орчны статистик;
- Хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд;
- Статистикийн чадавхийг бэхжүүлэх;
- Статистик ба орон зайн мэдээллийн нэгдмэл байдал;
- Статистикийн хөтөлбөрийн нэгдмэл байдал ба түүний зохицуулалт;
- Ерөнхий ассемблей болон Эдийн засаг нийгмийн зөвлөлийн бодлогын шийдвэрүүдийн биелэлт.

2.3 Хэлэлцэж шийдвэрлэсэн болон танилцуулсан асуудлаархи Монгол Улсын ҮСХ-ны санал

ҮСХ нь хэлэлцэж шийдвэрлэсэн 12 асуудал, танилцуулсан 14 асуудлаар саналаа боловсруулж хүргүүлсэн билээ (хавсралт 2). Чуулганы үеэр ҮТС, олон улсын худалдаа, эдийн засгийн глобальчлалын статистик, хөтөлбөрийн үнэлгээ ба хөгжлийг бүрэн төгс хэмжих нь, БОЭЗНД, хөгжлийн бэрхшээлийн статистикийн асуудлаар саналаа илэрхийлэв.

2.4 НҮБСК-ийн ээлжит 46-р чуулган

2014 оны 3-р сарын 6-ны өдөр НҮБСК-ийн ээлжит 46 дугаар чуулганы хөтөлбөр, холбогдох баримт бичгийн төслийг хэлэлцлээ. 46 дугаар чуулганаар Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн УБХБ-ийн тайланг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

III. Олон болон хоёр талт хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийсэн уулзалтууд

НҮБ-ын Статистикийн хэлтэс

ҮСХ-ны дарга С.Мэндсайхан тэргүүтэй төлөөлөгчид НҮБСХ-ны даргын үүрэг гүйцэтгэгч ноён Штефан Швайнфэсттэй 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдөр уулзлаа. Уулзалтын үеэр ҮСХ-ны дарга С. Мэндсайхан Монгол улс НҮБСК-ын чуулганд гурав дахь удаагаа Комиссын гишүүн орны хувьд оролцож, чуулганы асуудлаар санал, байр сууриа илэрхийлэн оролцож байгаагийн зэрэгцээ НҮБСХ-ны зүгээс Монгол Улсын ҮСХ-ны үйл ажиллагааг бүхий л талаар дэмжин ажиллаж байдагт талархал илэрхийлэв. Тэрээр Монгол Улсын ҮСХ нь олон улсын цогц үнэлгээ хийлгэж байгаа болон үнэлгээнээс гарах зөвлөмжид чухал ач холбогдол өгч буйгаа тэмдэглэн хэллээ. Түүнчлэн, ҮСХ нь НҮБСХ-ны дэмжлэгтэйгээр Хөгжлийн үзүүлэлтийн тооцоо/Ногоон эдийн засаг төсөлд оролцох Азийн 4 орны нэгээр сонгогдсондоо баяртай буйгаа илэрхийлж, 2015 онд НҮБСК-ийн 46-р чуулганд Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн УБХБ-ийн тайланг танилцуулахаа мэдэгдэв.

БНТУ-ын Статистикийн газар

ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, БНТУ-ын Статистикийн институтын дарга Бирол Айдемир нар 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдөр уулзаж, хоёр талын хамтын ажиллагаа, БНТУ-ын Статистикийн институтэд хийх ҮСХ-ны дарга С. Мэндсайханы албан ёсны айлчлалын талаар санал солилцлоо. Уг айлчлалын товыг урьдчилсан байдлаар 2014 оны 5-р сарын сүүлийн долоо хоног хэмээн тохиров. Дарга С. Мэндсайхан айлчлалын үеэр шинээр байгуулагдаж буй Туркийн Статистикийн сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах хүсэлтэй буйгаа илэрхийлэв. Ноён Бирол Айдемир Туркийн Статистикийн сургалтын төв нь 2014 оны 6-р сарын сүүлээр ашиглалтад орох тул айлчлалын үеэр зочлох боломжгүй байх магадлалтай ч айлчлалыг үр дүнтэй, харилцан ашигтай байх бүхий л арга хэмжээг авна хэмээн мэдэгдлээ. Дарга С. Мэндсайхан Монголд очсон даруйдаа айлчлалын товыг баталгаажуулж, хариу хүргүүлэхээр болов.

Австралийн Статистикийн Товчоо

2014 оны 3-р сарын 6-ны өдөр ҮСХ-ны дарга С. Мэндсайхан тэргүүтэй төлөөлөгчид Австралийн Статистикийн Товчооны (АСТ) дэд дарга Питер Харпертай уулзаж хоёр байгууллагын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Талууд нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн УБХБ-ийн хүрээнд идэвхитэй хамтран ажиллаж буйдаа сэтгэл хангалуун буйгаа онцлон тэмдэглэв. Дарга С. Мэндсайхан ноён П. Харперийг АСТ-ны даргын албан тушаалд өрсөлдөж буйг дэмжиж буйгаа илэрхийлэн амжилт хүслээ. Хоёр тал хамтын ажиллагааны хүрээнд НАХ, байгаль орчны данс байгуулах чиглэлээр танилцах айлчлал

зохион байгуулах боломжийн талаар ярилцаж, ойрын үед шийдвэрлэхээр болов. Түүнчлэн, УБХБ-ийн Удирдах хорооны 3-р хурал, 2014 онд хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцлоо.

НҮБЕЭЗНК-ын Статистикийн хэлтэс

ҮСХ-ны дарга С.Мэндсайхан НҮБЕЭЗНК-ын Статистикийн хэлтсийн дарга хатагтай Лидия Братановатай НҮБСК-ын чуулганы үеэр уулзав. Уулзалтын үеэр Монгол Улсын үндэсний статистикийн системийн олон улсын цогц үнэлгээний талаар ярилцаж, ҮСХ нь үнэлгээний үр дүнд чухал ач холбогдол өгч буй талаар дурдав. Дарга С. Мэндсайхан үнэлгээний үр дүнг түгээх ажлыг ДБ-ны хэрэгжүүлж буй Монстат төслийн үр дүн, Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төсөл зэргийг хамруулан олон улсын хурал хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж буйгаа дурьдаж, уг хурлыг 2014 оны 10-р сарын 29-нд зохион байгуулах хөтөлбөрийн төсөл боловсруулаад буйгаа тэмдэглэн хэллээ. Түүнчлэн, хурлын үйл ажиллагааг МУ-ын Парламентийн ордонд зохион байгуулж, НҮБЕЭЗНК, ДБ, ХБНГУ-ын Холбооны Статистикийн газар, БНСУ-ын Статистикийн газар, Түншлэлийн хүрээнд ҮСХ-нд ажилласан олон улсын болон үндэсний зөвлөхүүдийг урьж оролцуулахаар төлөвлөж буй талаар мэдээлэв. Хурлын үйл ажиллагаанд МУ-ын Их хурал, яамд, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөгчид мөн оролцох юм. Хатагтай Лидия Братанова олон улсын цогц үнэлгээ үр дүнтэй болно гэдэгт итгэж буйгаа илэрхийлж, үнэлгээний үр дүнг хэлэлцэх хурлыг дээд хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж буйг сайшаалаа. Дарга С. Мэндсайхан хатагтай Лидия Братановаг МУ-д ҮСС үүсч хөгжсөний 90 жилийн ойд урьлаа.

Норвегийн Статистикийн газар

2014 оны 3-р сарын 5-ны өдөр ҮСХ-ны дарга С.Мэндсайхан Норвегийн Статистикийн газрын дарга н.Олав Льонестэй уулзлаа. Дарга С. Мэндсайхан ноён Олав Льонесийг УБХБ-ийн өргөтгөсөн хуралдаанд оролцсонд талархахын ялдамд Хатагтай Жулия Хасс байгаль орчны данс байгуулах чиглэлээр Монстат төслийн хүрээнд ҮСХ-ны мэргэжилтнүүдтэй үр дүнтэй хамтран ажилласныг онцлон тэмдэглэв. Хатагтай Хассын зөвлөх үйлчилгээний үр дүнд МУ-ын ҮСХ нь НҮБСХ-ээс хэрэгжүүлж буй Хөгжлийн тооцоо/Ногоон эдийн засаг төсөлд хамрагдах болсон бөгөөд уг асуудлаар болсон салбарын хуралдаанд оролцсондоо сэтгэл хангалуун буйгаа илэрхийллээ. Хоёр тал Норвегийн статистикийн газарт танилцах айлчлал хийх, энэ асуудлаар Норвегийн Гадаад хэргийн яам, Бээжин дэх Норвеги улсын Элчин сайдын яамтай ярилцахаар тохиров. Дарга С. Мэндсайхан ноён Олав Льонест олон улсын цогц үнэлгээний 2 дахь удаагийн ажлын айлчлал амжилттай болсон талаар товч

мэдээлж, цогц үнэлгээний үр дүнгийн семинарт оролцоно гэж найдаж буйгаа илэрхийлэв. Түүнчлэн Норвегийн статистикийн газрыг УБХБ-ийн үйл ажиллагаа, Австрийн Вена хотноо болох Удирдах хорооны 3-р хуралд оролцохыг урьлаа.

ОХУ-ын Холбооны Статистикийн Алба

2014 оны 3-р сарын 3-ны өдөр ҮСХ-ны дарга С.Мэндсайхан ОХУ-ын Холбооны Статистикийн Алба (РОССТАТ)-ны дарга ноён А.Е.Суриновтой уулзаж, хоёр байгууллагын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Дарга С. Мэндсайхан ОХУ-ын Статистикийн алба Москва хотноо УБХБ-ийн Удирдах хорооны 2 дугаар хурлыг зохион байгуулсанд талархал илэрхийлж, Монгол Улсад үндэсний статистикийн систем үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээнд урьлаа.

БНСУ-ын Статистикийн газар

ҮСХ-ны дарга С. Мэндсайхан 2014 оны 3-р сарын 1-ний өдөр БНСУ-ын Статистикийн Газрын дарга Парк Хьонг Сүүтэй уулзаж, Статистикийн даргын албанд томилогдсонд баяр хүргэж, ажлын амжилт хүслээ. Дарга С. Мэндсайхан хоёр орны статистикийн байгууллагууд сүүлийн жилүүдэд үр дүнтэй хамтран ажиллаж буйг дурдаад ноён Парк Хьонг Сүүг энэ оны 7 дугаар сард ҮСХ-нд албан ёсны айлчлал хийхээр болсонд талархаж, хүлээн авахад бэлэн буйгаа илэрхийлэв.

IV. Улаанбаатар хотын бүлгийн өргөтгөсөн хурал

НҮБСК-ын ээлжит 45 дугаар чуулганы үеэр хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, жендерийн мэдээллийн стратеги, иргэний бүртгэл ба хүн амын ердийн шилжилт хөдөлгөөн, хүний хөгжил, хөгжлийн бэрхшээлийн статистик, хөдөө аж ахуй ба хөдөөгийн хөгжил, үндэсний статистикийн системийн санхүүжилт, мэдээллийн хувьсгал, нээлттэй мэдээ, байгаль орчин-эдийн засгийн дансны систем зэрэг нийт 62 салбар хуралдаанууд явагдсаны нэг нь Австрали, Монгол улсын санаачилгаар байгуулсан Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн УБХБ-ийн өргөтгөсөн хурал байлаа. Хуралд Австрали, Монгол, ОХУ, Япон, Казахстан, Энэтхэг, Норвеги, Мадагаскар, Мексик зэрэг орнуудын статистикийн байгууллага, НҮБСК, АНДЭЗНК, НҮБАҮХБ, АНДОСИ, ЭЗХАХБ, Нэг-Чили, ТУХН-ийн Статистик зэрэг олон улсын байгууллагын 20 гаруй төлөөлөгчид оролцсон юм.

УБХБ-ийн хурлыг ҮСХ-ны дарга С. Мэндсайхан, Австралийн Статистикийн Товчооны дэд дарга П. Харпер нэр нээж үг хэлэв. С. Мэндсайхан УБХБ-ийн бүтэц, зохион байгуулалт,

үйл ажиллагаа тогтворжин, гишүүн орнууд, дэмжигч олон улсын байгууллагын тоо жилээс жилд нэмэгдэж, хамтын ажиллагаа бодит үр дүнд хүрч буйг сайшаан тэмдэглэв. Тэрээр бүлгийн үйл ажиллагааг үндсэн дөрвөн чиглэлийн дагуу өргөжүүлэх, НҮБСК-ийн 46-р чуулганаар хэлэлцэх УБХБ-ийн тайланг боловсруулах зэрэг гишүүн орнуудаас идэвхтэй оролцоо, идэвхи чармайлт шаардсан ажлуудыг 2014 онд хийхээр төлөвлөж буйг тэмдэглэн хэлээд хурлын үйл ажиллагаанд амжилт хүслээ.

УБХБ-ийн хурлаар тус бүлгээс 2013 онд хэрэгжүүлсэн ажил, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, НҮБАҮХБ-ын дэмжлэгтэйгээр Австрийн Вена хотноо зохион байгуулах Удирдах хорооны 3-р хурлын хөтөлбөрийн төсөл, УБХБ-ийн үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны шинэ техник, технологийг өргөнөөр ашиглах талаар хэлэлцэв. 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд НҮБСК-ийн 46-р чуулганаар хэлэлцэх УБХБ-ийн тайлан, гарын авлага боловсруулах, Удирдах хорооны хурал зэрэг чухал ач холбогдолтой ажлуудыг тусгажээ.

V. Дүгнэлт


- Монгол улс нь НҮБСК-ийн гишүүн орны хувьд чуулганаар хэлэлцэх болон мэдээлэх асуудлуудтай урьдчилан танилцаж, холбогдох саналаа бичгээр бэлтгэн НҮБСХ-т албан ёсоор хүргүүлж, нэгдсэн чуулганы үеэр өөрийн орны санал, байр сууриа тодорхой асуудлуудаар илэрхийллээ (хавсралт 2).
- ҮСХ-ны төлөөлөгчид чуулганы салбар хуралдаануудад саналаа илэрхийлэх, илтгэл тавих, МУ-ын үндэсний статистикийн системийн ололт амжилт, санаачлагын талаар видео сурталчилгаа үзүүлэх, салбар хуралдаан зохион байгуулах зэрэг идэвхитэй байр суурь баримтлан оролцсоноор МУ-ын үндэсний статистикийн систем нь даяаршлын эрин үед олон улсын статистикийн нийгэмлэгтэй хөл нийлүүлэн алхаж байгааг харуулав.
- Чуулганд оролцсоноор ҮСХ нь бүс нутгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох боломжоо нэмэгдүүлж, АНДЭЗНК-ийн 4 дүгээр чуулганд олон улсын цогц үнэлгээний үр дүнгээр илтгэл тавих, УБХБ-ийн үйл ажиллагааг танилцуулахаар болов. Түүнчлэн, хөгжлийн тооцоо/ногоон эдийн засгийн төсөлд шинээр оролцох, хөрөнгийн эзэмшлийг хүйсээр тодорхойлох, жендерийн эрх тэгш байдлын талаархи мэдээлэл нотолгоо зэрэг судалгаа, төсөл хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдах, Вашингтон бүлгийн гишүүнээр үргэлжлүүлэн ажиллах, олон улсын чухал ач холбогдол бүхий хурал зөвлөгөөнд оролцох боломжоо нэмэгдүүлэв.

- Чуулганаас Монгол Австралийн хамтран санаачилсан Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн Улаанбаатар хотын бүлгийн тайланг 2015 онд болох НҮБСК-ийн ээлжит 46-р чуулганд танилцуулахаар шийдвэрлэв.
- Чуулганы үеэр УБХБ-ийн өргөтгөсөн хурлыг зохион байгуулж, бүлгийн үйл ажиллагааг дэлхийн статистикийн нийгэмлэг, олон улсын нэр хүндтэй мэргэжилтнүүдэд таниулж, сурталчлах бололцоог бүрдүүлэв. УБХБ-ийн хуралд гишүүн орнуудаас гадна гишүүн бус орон, байгууллагын төлөөлөгчид идэвхитэй оролцсон нь айлчлалын бас нэг үр дүн байлаа.
- НҮБСХ, олон талт болон хоёр талт хамтын ажиллагаатай байгууллагуудтай хийсэн уулзалтууд нь ҮСХ-ны гадаад хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байсны дээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн статистикийн тодорхой чиглэлээр цаашид төсөл хэрэгжүүлэх, судалгаа хийх, танилцах айлчлал, сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэх юм.

Чуулганы тайланд тусгагдсан зөвлөмжид тулгуурлан дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:


- Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд, нээлттэй болон “том” мэдээллийн албан ёсны статистикт үзүүлэх боломж, үр нөлөө, статистикийн шинэ салбарыг хөгжүүлэх шаардлага зэрэгт үндэслэн Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах;
- НҮБСК-ийн ээлжит 46-р чуулганд танилцуулах УБХБ-ийн тайланг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- НҮБСХ-ийн дэмжлэгтэйгээр ҮСХ-ны хэрэгжүүлэх хөгжлийн тооцоо/ногоон эдийн засаг төслийг хэрэгжүүлэх, олон улсын статистикийн хурал, сургалт семинарт оролцох, харилцан айлчлал хийх ажлуудыг ҮСХ-ны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газар болон бусад холбогдох газруудтай хамтран зохион байгуулах арга хэмжээ авах;
- ҮТС-ийн тооцоонд ERETES зэрэг программуудыг ашиглах боломжийг судлах;
- НҮБ-аас гаргаж буй, албан ёсны хэл дээр орчуулагдсан статистикийн арга зүйн баримт бичгүүдийг эх хэлнээ орчуулах.

Танилцсан:



С.Мэндсайхан /ҮСХ-ны дарга /

Илтгэх хуудас бичсэн:



С.Алтанцэцэг /МОНСТАТ төслийн зохицуулагч/

Хавсралт 1. НҮБ-ын Статистикийн Комиссын тухай товч танилцуулга

НҮБСК нь 1947 онд дэлхийн статистикийн системийн дээд байгууллага болон байгуулагдсан. Тус комисс нь дэлхийн өнцөг булан бүрээс гишүүн улс орон бүрийн статистикийн байгууллагуудын удирдлага болон олон улсын байгууллагуудыг нэгтгэн жил бүр нэг дор цуглуулдаг хамгийн том уулзалт бөгөөд жил бүрийн чуулганд 130 орчим улс орон, 40 орчим олон улсын байгууллага оролцдог байна.

Статистикийн комисс нь олон улсын статистикийн хөгжил, арга зүйн асуудал, олон улсын статистикийн хөтөлбөрүүдийн зохицуулалт, нэгдмэл байдал, статистикийн болон бусад үйл ажиллагааны чиглэлээр техникийн хамтын ажиллагааны дэмжлэг үзүүлэх зэрэг тусгай асуудлуудыг авч хэлэлцдэг. Тогтоолуудын хүрээнд НҮБСК нь шинээр гарч буй хэрэгцээ шаардлагад үйл ажиллагаагаа нийцүүлэх зорилгоор шаардлагатай үед өөрийн тэргүүлэх чиглэл, арга зүйгээ нийцрүүлэх, өнөөгийн тулгамдаад буй асуудал болон статистикийн системийн урт хугацааны хөгжлийн асуудлын тэнцвэрийг хангаж, уян хатан ажиллах боломжтой байдаг.

Үйл ажиллагаагаа тайлагнадаг байдал

Комисс нь чуулган тус бүрийнхээ талаар тайлан бэлтгэж, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл (НҮБЭЗНЗ)-д өргөн барьдаг. Тайланд Комиссын хурлын талаархи тайлан мэдээлэл, хэлэлцэх асуудал тус бүр дээр авсан арга хэмжээг тусгасан байдаг. Комисс нь НҮБ-ын гишүүн орнууд, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга буюу НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад хандан НҮБЭЗНЗ-д тогтоолын төсөл хэлбэрээр зөвлөмж өргөн барьж болдог. Өргөн баригдсан тогтоолын төслийг батлахаас өмнө НҮБСК, НҮБЭЗНЗ тус төслийн санхүүгийн аливаа үр дагаварыг хэлэлцэж, НҮБ-ын харьяа холбогдох эрх бүхий байгууллагуудын дэмжлэгийг авах ёстой.

Гишүүнчлэл

Газар зүйн байрлалын хувьд ижил тэгш оролцоотой байх зарчимд тулгуурлан НҮБЭЗНЗ-өөс эрхлэн явуулдаг гишүүний сонгуулиар сонгогдсон НҮБ-ын гишүүн 24 орноос тус комиссын гишүүд бүрддэг бөгөөд бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

- a) Африк тив - 5 улс
- b) Ази тив - 4 улс
- c) Зүүн Европын улсуудаас - 4 улс

- d) Латин Америк, Карибын улсуудаас - 4 улс
- e) Баруун Европ болон бусад улсуудаас - 7 улс тус тус гишүүнээр сонгогддог.

НҮБСК-ын гишүүнчлэлийн байдал – 2014

	Дуусах хугацаа
• Ангол улс	2017
• АНУ	2015
• Барбадос	2016
• Болгар	2016
• Бразили	2017
• БНХАУ	2016
• БНЧУ	2015
• Голланд улс	2016
• Доминиканы БНУ	2016
• Итали	2017
• Их Британи	2016
• Камерун	2017
• Куба	2015
• Либи улс	2017
• Монгол улс	2015
• Нигер	2015
• Оман	2015
• ОХУ	2017
• Танзанийн БНУ	2015
• ХБНГУ	2016
• Шинэ Зеланд	2017
• Швед	2017
• Унгар	2015
• Япон	2016

Хавсралт 2. Хэлэлцсэн, мэдээлсэн асуудлаархи Монгол улсын саналууд

А) Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлаархи санал

АЁС-ийн үндсэн зарчмуудын хэрэгжилт

- Юуны өмнө 20 жилийн хугацаанд Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд амжилттай хэрэгжиж, улмаар Унгар энэ асуудлаар шийдвэрийн төслийг танилцуулж, Монгол дэмжиж оролцсон нь батлагдсанд дэлхийн улс төрийн түвшинд тус зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн томоохон үйл явдал боллоо гэж үзэж байна.
- Энэ зарчим маань улс орнуудад зайлшгүй мөрдөж ажиллах ёстой, бодитой, хэрэгжих үндэслэлтэй зарчмууд юм гэдгийг тэмдэглэн хэлье.
- НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгээс баталсан Албан ёсны статистикийн үндсэн 10 зарчим бол статистикийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхэд эрхзүйн болон зарчмын баримт бичиг болж байгаа тул цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай юм.
- Улс орон бүхэн энэхүү статистикийн зарчмыг цаашид статистикийн хууль эрхзүйдээ тусган хангаж ажиллах шаардлагатай тул манай улсын хувьд “Статистикийн тухай” хуулиа шинэчлэн УИХ-д өргөн барьж батлуулахаар ажиллаж байна.
- Албан ёсны статистикийн үндсэн 10 зарчмаа хэрэгжүүлэх арга механизмыг улс орнууд бүрдүүлж, туршлагаа солилцож ажиллах шаардлагатай.

Хөтөлбөрийн үнэлгээ: Хөгжлийг өргөн хүрээнд хэмжих нь

- НҮБ-ийн Эдийн Засаг Нийгмийн Зөвлөлөөс гаргаж Европын холбооны комиссын 6-р сард баталсан сайн сайхан байдал, нийгмийн хөгжил дэвшил ба тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг манай улсын статистикийн хорооноос бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж байна.
- Дээрх үндсэн үзүүлэлтүүдийг хэмжих асуудал нь ЭЗХАХБ-аар батлагдсан бодлогын шинж чанартай 20 сэдвийн хүрээнд улс орон бүр аргачлал, аргазүйн хувьд нэгдмэл байхыг онцгой анхаарах шаардлагатай гэж үзэж байна.
- Мянганы хөгжлийн зорилтын сургамж, туршлагад тулгуурлан 2015 оноос хойших хөгжлийн хүрээний асуудлуудын тогтвортой, нэгдсэн хэмжилттэй хандлагыг бий болгоход онцлон анхаарах шаардлага зүй ёсоор гарч буй бөгөөд энд албан ёсны статистикийн болон бусад статистикийн (big data) нэгдсэн үзүүлэлтүүдийг оновчтой хамруулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Бодлого боловсруулагчдад явуулсан 8 санал бүхий мессеж болон хөтөлбөрийг бүрэн дэмжиж байна.
- Дарга нарын анд нөхдийн бүлгийн ажлын талаар:
 - Тогтвортой хөгжлийн болон сайн сайхан байдлын зорилтуудын талаар хийгдсэн ажил нь нэгдсэн үнэлгээтэй, оновчтой болсон тул батлахыг дэмжиж байна.
 - 2015 оноос хойших хөгжлийн асуудлуудын зорилтуудыг хэмжих талаар хийгдсэн ажлуудад нэлээд хүчин чармайлт гаргаж, багагүй үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Үндэсний тооцооны систем

Юуны өмнө ҮТС-2008 зөвлөмжийг улс орнуудад нэвтрүүлэх чиглэлд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа Inter Secretariat Working Group on National Accounts-д гүн талархал илэрхийлье. Цаашид ҮТС-2008 зөвлөмжийг улс орнуудад, ялангуяа хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд дараах асуудалд анхаарлаа хандуулахыг хүсье.

- ҮТС-2008 болон бусад холбогдох зөвлөмжүүд НҮБ-ын албан ёсны 6 хэл дээр орчуулагдаж байгаа бөгөөд тэдгээр хэлээр ярьдаггүй улс орнуудын хувьд зөвлөмжүүдийг өөрийн орны хөрсөн дээр яг ижил утгаар нь ойлгоход хүндрэлтэй байгааг анхааралдаа авахыг хүсч байна.
- ҮТС-ийн хүрээнд тооцооллыг хийхэд, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд гол хүндрэл бол ажиллах хүч, хөрөнгө санхүүгийн дутагдалтай байдал бөгөөд тооцоолол, техник ажлыг хөнгөвчлөх, оновчтой, ашиглахад хялбар, өртгийн хувьд бас хямд төсөр програм хангамжийг улс орнуудад санал болгож, дэмжлэг үзүүлэх нь дээрх хүндрэлийг багасгах нэг арга зам гэж үзэж байна.
- Тайлангаас харахад ҮТС-2008 зөвлөмжийн хүрээнд маш олон тооны сургалт, семинар, арга хэмжээг зохион байгуулсан байна. Гэвч тэдгээр нь улс орнуудын бодит хэрэгцээнд зориулсан арга хэмжээ болж чадаж байна уу гэдгийг харгалзан үзэж байх нь илүү ач холбогдолтой юм. Магадгүй зарим оронд зарим сургалт шаардлагагүй байхад зарим орнуудад нь нэн чухал хэрэгцээтэй байж болох юм.
- ҮТС-2008-ийг хэрэгжүүлэх нэг арга бол статистик нь өндөр хөгжсөн орнууд бүсийнхээ хөгжиж буй орноос нэгийг сонгож аваад “жишиг” орон болгож, жишиг болсон улс нь туршлагаа бүс нутагтаа цааш нь дэлгэрүүлэх замаар хөгжлийг түргэсгэх арга зам байж болох юм.

- Улс орнууд дотооддоо YTC-2008 болон BOPM6, GFSM-2014 зэрэг зөвлөмжүүдийн арга зүйн нэгдмэл байдлыг хангах нь чухал асуудал бөгөөд үүнд ОУБ-дын үйл ажиллагааг үүнд илүү чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Эцэст нь статистикийн байгууллагуудын тоон мэдээлэлд анализ дүгнэлт хийх чадварыг дээшлүүлэх нь мэдээллийн чанарыг бодит байдлаар үнэлэхэд чухал гэж үзэж байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлт болон ядуурлын хоорондын уялдаа, түүнийг илэрхийлж чадах үзүүлэлтүүдийг тооцож, тайлбарлахыг хэрэглэгчийн зүгээс байнга хүсч байдгийг энд дурьдмаар байна.

Байгаль орчин эдийн засгийн данс

Юуны өмнө БОЭЗДС Үндсэн хүрээ, 2012 (SEEA Central framework, 2012) зөвлөмжийг улс орнуудад нэвтрүүлэх чиглэлд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа Committee of Experts on Environmental-Economic Accounting-д гүн талархал илэрхийлье. Цаашид БОЭЗДС-2012, FDES-2013 зөвлөмжийг улс орнуудад, ялангуяа хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд дараах асуудалд анхаарлаа хандуулахыг хүсье.

- SEEA-2012, FDES-2013 нь НҮБ-ын албан ёсны хэлүүд рүү орчуулагдахаар болж байгааг тайланд дурьджээ. Гэтэл НҮБ-ын хэлээр ярьдаггүй улс орнуудын хувьд эдгээр зөвлөмжүүдийг өөрийн хэл дээр ижил утгаар нь ойлгоход хүндрэлтэй байна. Тиймээс уг зөвлөмжүүдийг эх хэл рүү мэргэжлийн болоод чанарын өндөр түвшинд орчуулан гаргахад тухайн улс орнууд дахь НҮБ-ын төлөөлөгчийн газраас санхүүгийн болоод техникийн туслалцаа үзүүлэхэд анхаарал хандуулахыг хүсч байна.
- Тайлангаас харахад SEEA-2012 зөвлөмжийн хүрээнд хэд хэдэн сургалт, семинар, арга хэмжээг зохион байгуулжээ. SEEA-ийн хэрэгжилтийг хангах хүний нөөцийн чадавхийг боловсронгуй болгох үүднээс энэ чиглэлийн сургалт, семинарын давтамжийг нэмэгдүүлэх, хөгжиж буй орны оролцогчдыг дан ганц статистикийн байгууллага, эсвэл байгаль орчны яамнаас биш, 2 байгууллагаас нэгэн зэрэг сонгон оролцуулах нь илүү үр дүнтэй болов уу гэж үзэж байна.
- SEEA-2012-ыг улс орнууд хэрэгжүүлэхдээ бүс, бүсээс байгаль орчны статистик, ногоон хөгжлийн үзүүлэлт, БОЭЗНДС нь өндөр хөгжсөн орныг сонгон тухайн бүсийн “жишиг” орон болгож, жишиг болсон улс нь туршлагаа бүс нутгийнхаа бусад улс орнуудад дэлгэрүүлэх аргыг нэвтрүүлж болох юм.
- Эцэст нь улс орнууд дотооддоо SEEA болон FDES зөвлөмжүүдийн нэгдмэл байдлыг ханган ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Олон улсын худалдаа, эдийн засгийн глобальчлалын статистик

Олон улсын худалдаа болон эдийн засгийн глобальчлалтай холбогдох олон асуудлыг хөндсөн илтгэл тавьж, хэлэлцүүлж байгаа Дарга нарын анд нөхдийн бүлэгт талархал илэрхийлье. Хэлэлцэж буй асуудалтай холбогдон дараах асуудалд анхаарлаа хандуулахыг хүсье.

- “Группын цаашдын үйл ажиллагааны хүрээнд улс орнуудын зүгээс ямар бэлтгэлийг хангавал зохистой вэ?” гэдэг талаар урьдчилан мэдээлэлтэй байх нь чухал гэж үзэж байна. Тухайлбал, улс орнууд НАХ, СХТ-ийг байгуулж, түүнийг хамгийн задгай түвшинд тархаах болж байна. Үүнтэй уялдан НАХ, СХТ-ийг байгуулах давтамж нь ямар байх вэ? нууцлалыг хэрхэн баталгаатай хангах вэ? гэдгийг улс орнууд одооноос мэдэх шаардлага гарч байна.
- Тухайн орнуудын хувьд худалдааны томоохон түнш орнуудтайгаа *mirror* статистикийг хөгжүүлж, экспорт, импортын хэмжээг үнэн бодитой гаргах нь бас нэг чухал асуудал гэж үзэж байна.
- Олон улсын худалдаа, Эдийн засгийн глобальчлалын статистик нь улс орнуудыг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг хөндөж байна. Үүнтэй уялдан холбогдох бүх аргачлал, ангиллыг уялдуулан авч үзэх шаардлага гарч байгаа бөгөөд тухайн улс орны түвшинд институудын сайн бүтцийг бий болгох асуудал ч энд хөндөгдөнө гэж үзэж байна.

Мэдээлэл, харилцааны технологийн хөгжилд гүйцэтгэх үүрэг

НҮБСК-ийн ээлжит 45 дугаар чуулганаар МХХТ-ийн статистикийн асуудлыг хэлэлцүүлж байгаад талархал илэрхийлж байна.

- Хавсралтад байгаа Өрх, хувь хүний МХХТ-ийн хэрэглээний үзүүлэлтийн засварласан жагсаалтыг батлахыг дэмжиж байна.
- МХХТ-ийн статистикийн хамрах хүрээн дэх үндэсний зохицуулалтыг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллага хоорондын хамтран ажиллах зохицуулалтын механизмыг бий болгох ажлыг үндэсний түвшинд сайжруулах нь чухал болж байгаа юм.
- Иймд 45 дугаар чуулганаар энэхүү үндэсний зохицуулалтыг улс орнуудад хэрхэн бий болгох талаар тодорхой санал, ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан хэлэлцэж шийдвэрлэвэл улс орнуудад МХХТ-ийн статистикийг сайжруулах ажилд томоохон туслалцаа үзүүлэх боломжтой юм.

- Мөн манай орны хувьд аргачлалаа сайжруулахтай холбоотой МХХТ-ийн хөгжлийг хэмжих хамтын ажиллагааны /Partnership on Measuring Information and Communication Technology for Development/ санал, зөвлөмжийг авах боломжийг эрэлхийлж байна.

Хөгжлийн бэрхшээлийн статистик

Хөгжлийн бэрхшээлийг хэмжих Вашингтоны бүлгийн боловсруулсан тайланг дэмжиж байгаа бөгөөд 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг сайшааж байна. Монгол Улсын ҮСХ нь хөгжлийн бэрхшээлийн статистикийг боловсронгуй болгох, мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байна. Тухайлбал, мэдээллийн маягт зааврыг шинэчилж, албан ёсны статистикийн мэдээллээр цуглуулдаг үзүүлэлтийн хүрээг өргөтгөлөө. Илтгэлтэй холбогдуулан дараах саналуудыг дэвшүүлж байна:

- Монгол Улс нь Вашингтон бүлгийн гишүүнээр цаашид үргэлжлүүлэн ажиллах саналтай байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарын үзүүлэлтүүдийг тооцох чиглэлд Вашингтон бүлэг анхаарвал зүйтэй болов уу.
- Хөгжлийн бэрхшээлийн асуулгын ойлгомжтой байдлын судалгаа болон асуулга турших туршилтын судалгааг явуулахад техникийн дэмжлэг туслалцаа авах хүсэлтэй байна.
- Бүс нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлийн статистикийн чиглэлээр чадавхи бэхжүүлэх, хөгжиж буй орнуудын статистикийн байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах нь чухал байна гэж үзэж байна.

Том мэдээлэл ба статистикийн системийн шинэчлэл

Өнөө үед тоон мэдээлэл нь олон төрлийн арга замаар дижитал хэлбэрээр автоматаар болон тасралтгүй байдлаар бий болж байна. Эдгээр олон төрлийн тоон мэдээллийн эх үүсвэр нь нийгэм, байгаль орчин, санхүү болон эдийн засгийн хандлагыг өндөр нарийвчлалтайгаар, түргэн шуурхай тооцох үүднээс албан ёсны статистикт ашиглах бодит сонирхолыг бий болгож байна.

Үндэсний статистикийн байгууллагуудын эрхлэн гаргадаг албан ёсны статистик мэдээллийн нэг гол эх үүсвэр нь захиргааны статистик мэдээлэл юм. Захиргааны статистик мэдээлэл нь том мэдээллийн эх үүсвэр гэж одоогоор тооцогдохгүй байгаа боловч жилд эсвэл сард нэг удаа цуглуулахаас илүүтэйгээр тухайн цаг хугацаанд нь эсвэл өдөр, долоо хоногийн

давтамжтайгаар цуглуулах замаар захиргааны статистик мэдээллийг өргөн хүрээнд статистикийн байгууллагууд ашиглаж эхэлвэл том тоон мэдээллийн эх үүсвэр болох боломжтой юм.

Албан ёсны статистикт том тоон мэдээллийг ашиглахад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байна. Үүнд:

- Хууль, эрх зүй: Өөрөөр хэлбэл тоон мэдээллийг авч ашиглахтай холбоотойгоор
- Хувийн нууц: Өөрөөр хэлбэл тоон мэдээллийг дахин ашиглах, түүнийг бусад эх үүсвэртэй холбох асуудлаар олон нийтийн итгэл, дэмжлэгийг олж авах
- Санхүүгийн хувьд: Өөрөөр хэлбэл тоон мэдээллийн эх үүсвэрийг ашиглахад гарах зардал, ашигтай ямар харьцаатай байна вэ
- Менежментийн хувьд: Жишээ нь: тоон мэдээллийн менежмент, хамгаалалтанд баримтлах бодлого, чиглэл
- Аргачлалын хувьд: Өөрөөр хэлбэл тоон мэдээллийн чанар, статистикийн аргачлалтай хэр нийцэж байна вэ
- Технологийн хувьд: Өөрөөр хэлбэл мэдээллийн технологитой холбоотой асуудлууд

НҮБСХ-ээс эрхлэн гаргадаг хэвлэмэл бүтээгдэхүүнүүд

- НҮБ-ын Статистикийн хэлтсээс гаргадаг жилийн эмхтгэлүүдийг цаашид цахим хэлбэрээр тархаах нь зүйтэй гэж үзэж байна.
- Харин нэн шаардлагатай аргачлалын материалуудыг ҮСХ-ны номын сангаар дамжуулан оюутан, судлаач, олон нийтэд хүргэдэг тул хэвлэмэл байдлаар авах сонирхолтой байна.

НҮБ-ын системийн хүрээнд статистикийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

Бид НҮБ-ын системийн хүрээнд статистикийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж буй Дарга нарын анд нөхдийн бүлгийн тайланг сайшаан дэмжиж байна. Монгол улсын хувьд ҮСХ нь GSBPS-д суурилсан нэгдсэн МТ-ийн системийг багтаасан статистикийн үйлдвэрлэлийн системийг нэвтрүүлэхийг зорьж байна. Энэхүү системийг ДБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх юм. Уг системийн нэг хэсэг болох статистикийн нэгдсэн мэдээллийн сайнг байгуулаад байна.

Дэлхийн статистикийн өдөр

- ҮСХ нь 2013 оны 11 дүгээр сард Дэлхийн статистикийн өдрийг 2015 оны 10 дугаар сарын 15 эсвэл 11 дүгээр сарын 11-нд “Хэрэглэгчийн статистикийн боловсролыг дээшлүүлэх нь” сэдвээр тэмдэглэе гэсэн саналыг НҮБ-ын Статистикийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн билээ.
- Глобал хэлэлцүүлгийн хүрээнд олонхийн дэмжлэг авсан 2015 оны 10 сарын 20-ы өдрийг Дэлхийн Статистикийн өдөр болгон “Статистик - илүү оновчтой шийдвэр гаргах, –статистик- илүү үр ашигтай хөгжлийн төлөө” сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлэхийг бүрэн дэмжиж байна.
- Монгол Улсын ҮСХ-ны зүгээс тэмдэглэлт өдөрт бэлтгэх зорилготойгоор өөрийн цахим хуудсыг хөгжүүлэх, бусад хэвлэмэл бүтээгдэхүүнийг хэвлэн тархаах, сургалт сурталчилгааны чиглэлээр уулзалт, семинар зохион байгуулахад НҮБ-ын статистикийн хэлтсээс дэмжлэг авах хүсэлтэй байна.

Бүс нутгийн статистикийн салбарын хөгжил

Бид МХЗ-ыг хэрэгжүүлсэн туршлага дээрээ тулгуурлах нь зүйтэй гэж үзэж байна. Хэдийгээр өндөр хөгжилтэй орнууд суурь байдлаа оновчтой тодорхойлж, хөгжлийн өөрчлөлт дэвшлийг сайн хэмжиж чадсан бол олонхи хөгжиж буй орнууд мэдлэг чадвар, хөрөнгө, институцийн дутагдалтай байдал зэрэг асуудалтай тулгарсан билээ. МХЗ-ыг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрт үндэсний статистикийн системийн чадавхийг бэхжүүлэх асуудал бүрэн төгс тусгалаа олоогүй юм. Ийм учраас МХЗ-ын үзүүлэлтийг хэмжих, түүнийг хэрэгжүүлэх нь ҮСХ-ны хувьд томоохон даваа, сорил байв.

Дээрхи сургамж, туршлагаас сургамж авч 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөр, улс орнуудын засгийн газар ба үндэсний статистикийн системийн харилцан үйлчлэх нөлөө, уялдаа холбоог эхнээс нь хангаж, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт үнэлгээний оновчтой тогтолцоог бий болгох хэрэгтэй юм. Иймээс Хөгжлийн хөтөлбөрт статистикийг нэг зорилт болгон тусгах гэдэг саналыг дэмжиж байна. Үүний үр дүнд улс орнуудын Засгийн газар нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөртөө ҮСС-ийн хөгжлийн асуудлыг тусгаж, улмаар улс орон бүрийн статистикийн байгууллага нь статистикийн системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөртөө “хөгжлийн шинэ мэдээллийг бий болгоход” чиглэсэн зорилтуудыг тусган, шинэчлэн боловсруулах нөхцөл бүрэлдэнэ. Ийм арга замаар олон улсын хөгжлийн байгууллага, засгийн газрын нөөцийг үр ашигтай зарцуулах, чадавхийг дээшлүүлэх оновчтой хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ гэж үзэж байна.

В) Мэдээлэх асуудал

Хүн ам зүйн статистик

Хүн ам зүйн статистикийн асуудлаар хэлэлцэж буй энэхүү илтгэлийг дэмжиж байна. НҮБ-ын Статистикийн хэлтэс иргэний бүртгэл ба ердийн хөдөлгөөний статистикийн мэдлэгийн төв <http://unstats.un.org/unsd/vitalstatkb> -ийг бий болгож улс орнууд мэдээлэл солилцох, мэдлэгээ хуваалцах боломж олгож байгаад талархал илэрхийлье.

Танилцуулж буй илтгэлтэй холбогдуулан дараах саналтай байна:

- “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийг шинэчлэх ажлын хэсгийн үйл ажиллагаанд Монгол Улсын ҮСХ идэвхтэй хамтран ажиллана.
- НҮБ-аас тооллого хоорондын судалгаа явуулах талаар нэгдсэн гарын авлага, зөвлөмж боловсруулж, улс орнууд тооллого хоорондын судалгаа явуулах талаар туршлагаа солилцох боломжийг бүрдүүлэх.
- НҮБ-ын Статистикийн Хэлтэс “Ердийн хөдөлгөөний статистикийн системийн зарчим, зөвлөмжүүд”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүсийн болон дэд бүсийн цуврал сургалт/семинар (workshop) зохион байгуулахаар төлөвлөж байгааг сайшаан дэмжихийн зэрэгцээ хөгжиж буй улс орнуудын бүрэн оролцоог хангаж ажиллахыг санал болгож байна.

Хүн амын суурьшлын статистик

Хүний суурьшлын статистикийн асуудлаар илтгэл бэлтгэн танилцуулж байгааг сайшааж байна. Монгол Улсын ҮСХ нь хүн ам, орон сууцны тооллого, түүвэр судалгааны үр дүнгээр сайжруулсан ариун цэврийн байгууламжид хангагдаагүй хүн амын эзлэх хувь, баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь, инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь гэсэн илтгэлд дурьдсан зарим үзүүлэлтүүдийг гаргаж байна.

Хүн амын суурьшлын статистикийн талаарх мэдээлэх асуудалтай холбогдуулан өгөх санал:

- Хөгжиж буй орнуудад эзэмшлийн баталгаат байдал хангагдаж чадахгүй байгаа учраас НҮБ-ХАБИТАТ, тэдний түншлэгчид улс орон, бүс нутгийн хэмжээнд боловсруулсан эзэмшлийн баталгаат байдлыг хэмжих аргачлалыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэх
- Хөгжиж буй улс орнууд хүн ам, орон сууцны тооллого, түүвэр судалгаануудад модуль асуулгаар эсвэл хот суурин газрын тэгш бус байдлын тусгайлсан судалгаагаар

эзэмшлийн баталгаат байдалтай холбоотой мэдээлэл цуглуулдаг болоход НҮБ болон бусад олон улсын байгууллагууд арга зүйн болон техникийн туслалцаа үзүүлэх

Жендэрийн статистик

Монгол Улсын ҮСХ танилцуулж буй илтгэлийг дэмжиж байгаагийн зэрэгцээ уг илтгэлд дурьдсан хүрээг батлагдахаар үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. ҮСХ нь жендэрийн статистикийг боловсронгуй болгох, албан ёсны статистикийг жендэрийн мэдрэмжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Монгол Улсын Жендэрийн статистикийн үзүүлэлтийн хүрээг 14 бүлгийн 216 үзүүлэлтээр боловсруулж мөрдөж байна.

Мэдээлж буй асуудалтай холбогдуулан өгөх санал:

- Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааг зохион байгуулж явуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа, зөвлөмж авч ажиллах;
- Хөрөнгийн эзэмшлийг хүйсээр тодорхойлох нь судалгааг зохион байгуулах талаар дэмжлэг туслалцаа зөвлөмж авч ажиллах;

Мансууруулах бодис, түүний хэрэглээний статистик

Мансууруулах бодисын статистикийн чанар, хүртээмжийг сайжруулах асуудлаар илтгэл бэлтгэн танилцуулж байгаа нь цаг үеэ олсон чухал мэдээлэл болж байна гэж үзэж Монгол Улсын ҮСХ илтгэлийг сайшаан дэмжиж байна.

Тайлантай холбогдсон санал:

- Мансууруулах бодисын хэрэглээ, нийлүүлэлтийн статистикийн чиглэлээр хөгжиж буй орнуудын чадавхийг бэхжүүлэх, олон улсын уулзалт, арга хэмжээг зохион байгуулах
- Мансууруулах бодисын талаарх мэдээллийг цуглуулах, тайлагнах, олон улсын нэгдсэн арга зүйг нэвтрүүлэхэд дор хаяж Лисбоны хэлэлцээрт заасан үзүүлэлтүүдийг гаргадаг болоход хөгжиж буй орнуудад техникийн дэмжлэг туслалцаа авах
- Арга зүйг сайжруулах, шинээр боловсруулах

Гадаад шилжих хөдөлгөөний статистик

Гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн эх үүсвэрүүд, шилжих хөдөлгөөний мэдээллийн хүртээмжтэй байдал, олон улсын түвшинд мэдээлэл гаргахад тохиолдож буй саад бэрхшээлүүд, гадаад шилжих хөдөлгөөний статистикийн талаар олон улсын байгууллагуудын одоогийн хиж буй болон хийхээр төлөвлөж буй ажлуудыг танилцуулсан илтгэлийг дэмжиж байна.

Тайланд өгөх санал:

- Улс орнууд шилжин ирэгч, явагчдын мэдээллийг хоорондоо солилцдог байх механизмыг бий болгох;
- Олон улсын болон үндэсний түвшинд харьцуулагдах боломжит мэдээллийн санг бий болгох чиглэлээр нэгдсэн аргачлалаар хангаж ажиллах;
- Гадаад шилжих хөдөлгөөний статистик мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд хөгжиж буй орнуудын статистикийн байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, гадаад шилжих хөдөлгөөний статистикийн асуудлаар олон улсын болон бүсийн хэмжээний уулзалт, хурал арга хэмжээ зохион байгуулах

Соёлын статистик

Чуулганд танилцуулж байгаа тайланг дэмжиж байна.

Тайлантай холбогдсон санал:

- Захиргааны мэдээллийн эх үүсвэрээс гарах боломжгүй үзүүлэлтийг гаргах түүвэр судалгаа явуулах талаар нэгдсэн гарын авлага, зөвлөмж боловсруулж, улс орнууд судалгаа явуулах талаар туршлагаа солилцох боломжийг бүрдүүлэх
- Соёлын статистикийн чиглэлээр улс орнуудын статистикийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарах.

ХАА, хөдөөгийн статистик

Хөдөө аж ахуй, хөдөөгийн статистикийг сайжруулах Олон улсын Удирдах хорооны тайлантай танилцлаа. Танай хамт олны цаашдын ажилд амжилт хүсье.

- Монгол Улсын Үндэсний статистикийн тогтолцооны олон улсын цогц үнэлгээний багийн зөвлөсөн захиргааны статистик мэдээллийн чанарт анхаарал хандуулах.
- Хөдөө аж ахуйн завсрын болон дараагийн тооллогыг зохион байгуулахдаа Хүн ам орон сууцны тооллоготой харилцан хамааралтай мэдээллүүдийг судлах.
- 2012 онд шинээр батлагдсан Монгол Улсын “Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль” –тай холбогдуулан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт тооцох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох.
- Мал тооллогын мэдээллийн санг Бизнес регистрийн сантай холбох зэрэг болно.

Эрчим хүчний статистик

Юуны өмнө эрчим хүчний Олон улсын гарын авлагыг шинэчлэн боловсруулж байгаад талархал илэрхийлж байна. Энэхүү олон улсын зөвлөмж нь эрчим хүчний статистикийн үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, хамрах хүрээ, эрчим хүчний олон улсын ангилал, хэмжих нэгж, мэдээллийн эх үүсвэр, мэдээллийн тархаалт зэргийг авч үзэхдээ үндэсний

тооцооны систем болон бусад статистиктай уялдуулан системтэйгээр, цогц байдлаар авч үзсэн нь сайшаалтай болжээ. Энэхүү олон улсын зөвлөмжийг бид дэмжиж байгаа бөгөөд бүлгийн ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах 2 саналыг өгч байна. Үүнд:

- Эрчим хүчний олон улсын зөвлөмжийг нэвтрүүлэхэд хөгжиж буй орнуудад зөвлөх ажиллуулж, тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан гадаад, дотоодын сургалт зохион байгуулах ажлыг төлөвлөгөөндөө тодорхой тусгаж өгөх.
- Монгол Улсын хувьд түлш, эрчим хүчний нэгдсэн баланс, түүний шинжилгээг 2014 онд багтаан байгуулахаар “Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эрчим корпораци” ажиллахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Баланс байгуулахад манай орны хувьд туршлага дутмаг байгаа тул энэ чиглэлээр зөвлөгөө авах хүсэлтэй байна.

Үйлчилгээний гадаад худалдааны статистик (ҮГХС)

- “ҮГХС-ын гарын авлага 2010”-н удирдамжийг дэмжиж байна.
- Үйлчилгээний гадаад худалдааны статистик мэдээллийг зөвхөн Монгол банкнаас Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтийг авч ДНБ-ий тооцоонд тусгадаг. Энэ нь үйлчилгээний гадаад худалдааны статистикийн нэг хэсэг болно. Иймд шинээр тооцогдох үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэрийг бий болгоход туршлага судлах
- Хөгжиж буй орнуудад төлбөрийн тэнцлийг зохиох аргачлал (BPM6)-г бүрэн нэвтрүүлэхэд шинээр нэмэгдэн орж буй үйлчилгээний төрлүүдтэй (Бусдын эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх үйлчилгээ, оюуны өмч ашиглах эрхийн хураамжийн үйлчилгээ) холбоотойгоор олон улсын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх

Үнийн статистик

Цаашид дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- Монгол улсын Үндэсний статистикийн тогтолцооны олон улсын цогц үнэлгээний багийн зөвлөсөн дундаж үнийг тооцоход геометр дунджийг ашиглах асуудлыг судлах.
- Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийг сонгогдсон цэгээс Tablet ашиглан цуглуулж эхлэх.
- Улирлын нөлөөллийг арилгасан индексийн тооцоо хийх боломжийг судалж, нэвтрүүлэх.

Ottawa Group-д хүргүүлэх санал, хүсэлт:

Оттава группын 2015 оны 5-р сард Япон улсад зохион байгуулагдах уулзалтаар хэлэлцэгдэх дараах асуудлуудыг өөрийн оронд нэвтрүүлэхэд зөвлөмж авах хүсэлтэй байна.

Үүнд:

- Үнийн индексэд *scanner data* ашиглах;
- Үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс тооцох;

Богино хугацааны эдийн засгийн үзүүлэлтүүд

Танилцуулж буй асуудалтай холбогдуулан дараах хүсэлтийг тавьж байна.

Богино хугацааны статистикийн аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа болон бусад үйлчилгээний салбарыг хамарч байна.

Өнөөгийн нөхцөлд богино хугацааны статистик мэдээлэл нь ирээдүйн эдийн засаг, нийгмийн үйл явцад бий болох эерэг, сөрөг талыг урьдчилан харах боломжийг олгох чухал асуудал бөгөөд үүнийг зөвхөн үзүүлэлтийн хүрээгээр хязгаарлалгүй, цогц байдлаар авч үзэж байгаад талархаж байна.

Эдийн засгийн богино хугацааны үзүүлэлтийн талаар 45 дугаар чуулганаар танилцуулж буй асуудалтай холбоотой дараах саналыг оруулж байна. Үүнд:

- Боловсруулж буй гарын авлагуудад практик жишээг, богино хугацааны статистикийн чиглэлээр шилдэг туршлагатай улс орнуудын жишээгээр баяжуулан оруулж өгөх, энэ нь хөгжиж буй орнуудад шууд авч хэрэгжүүлэх түвшинд ойлгомжтой, тодорхой тусгагдсан байвал илүү өгөөжтэй байх болно.
- Эдийн засгийн хандлагын судалгааг улс, орны статистикийн байгууллагууд ямар цаг хугацааг хамарч явуулахыг тодорхой зааж өгөх. Тухайлбал тогтвортой эдийн засгийн үед судалгааг заавал зохион байгуулсаар байх уу гэдэг талаар нэмэлт тайлбар өгөх.
- Богино болон урт хугацааны статистик мэдээллээр үндэсний мэдээллийн нэгдсэн санг байгуулах нь үйл ажиллагааны автоматжилт, мэдээллийн цахим системийн ашиглалтыг өргөжүүлэхэд ихээхэн чухал юм. Иймд улс орнуудын богино хугацааны статистик мэдээлэл цуглуулалт, тархаалтын системийг сайжруулах, онлайн технологид шилжих чиглэлээр тусгайлсан зөвлөмж боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Байгаль орчны статистик

- Өөрийн үнэлгээг улс орон бүр хэрхэн хийх талаар техникийн зөвлөгөөг өгөх, сайн туршлагыг нэвтрүүлэх;
- Улс орнуудад үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх сургалт явуулж, чадавхийг бэхжүүлэх;
- Үндсэн чиглэлийг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараалал, хэрэгжүүлэх хугацааг нь тодорхой тусгаж өгөх

Хөгжлийн үзүүлэлтүүд

Чуулганд танилцуулж байгаа илтгэлийг сайшааж байна. МХЗ-ын хэрэгжилтийн сургамжинд үндэслэн 2015 оноос хойшхи хөгжлийн асуудлыг хэлэлцэх, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо статистикийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл, арга зүйг боловсронгуй болгох, нэгдмэл байдлыг хангах, улс орнууд мэдээлэл солилцох, мэдлэг хуваалцах боломжийг нэмэгдүүлэх зэрэгт анхаарах шаардлагатай байна.

Статистикийн чадавхийг бэхжүүлэх

Монгол Улсын хөгжлийн байдлыг илтгэн харуулах хөгжлийн шинэ үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд тодорхойлж тооцох, бодит мэдээллийг бий болгох асуудал ихээхэн чухал байгаа өнөө үед статистик, мэдээллийн хэрэгцээ, түүний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Түүнчлэн, Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүд, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, асуудлаарх үндэсний хөтөлбөрүүд, түүнд чиглэсэн олон улсын байгууллагуудын төслүүдийн хэрэгжилтийг үнэлэх, мониторинг хийх зэрэгт үндэслэл сайтай статистикийн үнэн бодит мэдээллийн хэрэгцээ, шаардлага байгаа юм.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу УИХ-ын 2006 оны 07 тоот тогтоолоор батлагдсан “Албан ёсны статистикийг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг ҮСХ амжилттай хэрэгжүүлж, тайлангаа УИХ-д танилцуулсан.


УИХ-ын 2011 оны 12 сарын 01-ний 59-р тогтоолоор Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил хийгдэж байна.

Бусаны статистикийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаатай болгох, үр дүнгийн хяналт, мониторинг хийх шинэ арга хэрэгслийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Статистикийн хөтөлбөрүүдийн уялдааг хангах, нэгтгэх нь

Статистикийн үйл ажиллагааны зохицуулалтыг хангах Хорооны тайланг бид бүхэн дэмжиж, статистикийн байгууллага нь 2015 оноос хойших Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахад тэргүүлэх үүрэгтэй оролцож, олон улсын болон үндэсний хэмжээнд идэвхтэй ажиллах шаардлагатай гэдэгтэй санал нэг байна.

Хавсралт 3. Улаанбаатар хотын бүлгийн хуралдааны хөтөлбөр



**“БАЙГАЛИЙН НӨӨЦӨД СУУРИЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН
СТАТИСТИК”-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН БҮЛГИЙН
ӨРГӨТГӨСӨН ХУРАЛ**

Огноо: 2014.03.03

Даваа гариг

Цаг: 18.15-19.15

Байршил: НУБ-ын төв байр, Хурлын “А” Танхим

№	Үйл ажиллагаа	Цаг
1	Хурлын нээлт: <ul style="list-style-type: none">• ҮСХ-ны Дарга С. Мэндсайхан• Австралийн Статистикийн товчооны Дэд дарга П. Харпер	18.15 - 18.25
2	<ul style="list-style-type: none">• “УБХБ-ийн үйл ажиллагаа” илтгэл	18.25 - 18.35
3	<ul style="list-style-type: none">• Байгалийн нөөцийн статистикийн талаархи АСТ-ы мэдээлэл	18.35 – 18.45
4	<ul style="list-style-type: none">• УБХБ-ийн 2014 оны ажлын төлөвлөгөө• УБХБ-ийн үйл ажиллагаанд МХТ-ийг ашиглах нь• Австрийн Вена хотноо зохион байгуулагдах Удирдах хорооны хурлын хөтөлбөрийн төсөл	18.45 – 19.00
5	<ul style="list-style-type: none">• Асуулт, хариулт	19.00 – 19.10
	<ul style="list-style-type: none">• Хурлын хаалт	19.10 - 19.15

Хавсралт 4. Товчилсон үг

Монгол үгийн товчлол

АНДЭЗНК- Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн статистикийн комисс
АНДОСИ-Ази, Номхон далайн орнуудын статистикийн институт
АСТ-Австралийн статистикийн товчоо
БОЭЗНД-Байгаль орчин-эдийн засгийн нэгдсэн данс
БНСУ-Бүгд Найрамдах Солонгос Улс
БНУУ-Бүгд Найрамдах Унгар Улс
БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ-Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ-Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МУ-Монгол улс
МХХТ-Мэдээлэл, харилцаа, холбооны технологи
НАХ-Нөөц ашиглалтын хүснэгт
НҮБ-Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБАҮХБ-НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
НҮБСК-НҮБ-ын Статистикийн комисс
НҮБСХ-НҮБ-ын Статистикийн хэлтэс
НҮБЭЗНК-НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн комисс
СХТ-Салбар хоорондын тэнцэл
УБХБ- Улаанбаатар хотын бүлэг (Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн
Улаанбаатар хотын бүлэг)
ТУХН- Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг
ҮГХС-Үйлчилгээний гадаад худалдааны статистик
ҮСС-Үндэсний статистикийн систем
ҮСХ-Үндэсний статистикийн хороо
ҮТС-Үндэсний тооцооны систем
ХАОСТ-Хүн ам орон сууцны тооллого
ХБНГУ-Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЭЗХАХБ-Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага

Англи үгийн товчлол

CRVS-Civil registration and vital statistics

EDGE-Evidence based data for gender equality

ESCAP- Economic and Social Commission for Asia and the Pacific

FDES-Framework for the development of environmental statistics

ICR-International Comparison Program

ICT- Information and Communicatiaon Technology

ISWGNA-Inter Secretariat Working Group on National Accounts

SEEA-System of Environmental-Economic Accounts

SEEA-System of Environmental-Economic Accounts